

УЛС ТӨРИЙН ТОТАЛИТАРИ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХАННА АРЕНДТЫН ҮЗЭЛ САНАА

Ж.Жаргал

(Улс төрийн ухааны магистрант)

Нийгмийн сэтгэлгээний тодорхой үед нийгмийн ямар нэгэн үзэгдэл, асуудлыг судлаж бичсэн зохиол бүтээл цаг үе улиран өнгөрсний дараа өөрөө эргээд судлагдахуун болдог, өөрөөр хэлбэл тухайн шинжлэх ухааны түүхийн нэг асуудал болж тавигддаг байна. Энэ нь ялангуяа нийгмийн ухаан, тэр дотор философи, социологи, улс төрийн шинжлэх ухаанд нийтлэг тохиолдож тод ажиглагддаг ажээ. Энэчлэн 1940- өөс 1950 – иад онд тоталитаризмын асуудлаар өрнөдөд гарсан томоохон суурь бүтээлүүдийн онолын үзэл санаа, арга зүйн баримтлал, дүгнэлтийг өнөөдөр улс төрийн сэтгэлгээний түүхийн аспектээр эргэн харж судлах хэрэгцээ шаардлага гарч ирж байна.

Улс төрийн тоталитар дэглэм ХХ зуунд дэлхийн арав гаруй оронд тухайн үеийн түүхэн нөхцөл байдал, тодорхой шалтгаан, холбогдох хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсэн тогтож тэдгээр орны нийгэм, хүн ардын амьдралд гашуун зовлон учруулж, “бэртэл”, “сорви” үлдээсэн билээ. Тиймээс ч тоталитаризмын асуудлыг К.Поппер, Ф.Хайек, Х.Арендт, К.Фридрих, З.Бжезински, Р.Арон, Ж.Орвелл, Х.Ортега–и-Гассет, Э.Фромм, Т.Адорно, Н.А.Бердяев, М.Жилас, Ж.Желев, А.П.Бутенко, А.Галкин, Я.С.Драбкин, я Ю.Н.Давыдов зэрэг гадаадын нэртэй эрдэмтэд 1930- аад оны сүүлч үеэс өдгөө хүртэл авч үзэн судлаж олон арван ном бүтээл туурвижээ. Тэдгээр ном зохиол нь тоталитаризм хэмээх ХХ зууны түүхэн үзэгдэлийг судлаж танин мэдэх, онолын үүднээс нэгтгэн дүгнэхэд жинтэй хувь нэмэр болсон байна.

Ном зохиолд улс төрийн дэглэмийг ардчилсан ба ардчилсан бус гэсэн үндсэн хоёр хэв маягт хуваан ангилж, хоёр дахь нь тоталитаризм ба авторитаризмыг өөртөө багтаадаг тухай үзэл санаа хэвшсэн билээ. Тоталитаризмыг дэлхийн янз бүрийн оронд тогтож ноёрхсон байдал, онцлогийг нь харгалзан үзэж дотор нь “зүүн” ба “баруун” гэсэн хоёр гол хэлбэртэй гэж үзээд, “зүүн” тоталитаризм нь коммунист шинж агуулгатай бөгөөд хуучны ЗХУ, Зүүн Европын орнууд, Хятад, Хойд Солонгос, Умард Вьетнам, Куба, Монголд, “баруун” тоталитаризм нь фашист, нацист хэлбэрээр Итали, Германд тогтон ноёрхож байсан талаар эрдэмтэд заасан байдаг.

Нэр дурдсан эрдэмтэдийн ном зохиолын дотроос Х.Арендтын зохиолууд онцгой байр суурь эзэлдэг ажээ. Дэлхийн нийгэм судлагч эрдэмтэдийн ихэнх нь Х.Арендт бол ХХ зууны улс төрийн сэтгэлгээ, тэр дотор улс төрийн философийн сонгодог төлөөлөгчийн нэг бөгөөд түүний туурвисан “Тоталитаризмын эх үүсвэр” хэмээх зохиол нь тоталитаризмын асуудлаар Өрнөдөд гарсан цөөн тооны суурь бүтээлийн нэг мөн гэж үздэг байна. Эл зохиол том форматаар хэвлэгдсэн, 40 гаруй хэвлэлийн хуудастай, 3 том хэсэг (анги), 30 бүлэгтэй том хэмжээний нэгэн сэдэвт бүтээл бөгөөд англи, герман, франц, орос зэрэг хэд хэдэн хэлээр хэвлэгдэн гарсан ба түүнийг нийгмийн ухааны эрдэмтэд судлан үзэж олон арван ном зохиол, өгүүлэл сэлт нийтлүүлжээ.

Тоталитаризмын тухай Х.Арендтын үзэл баримтлалыг энэхүү гол зохиолынх нь дагуу судлах онол–танин мэдэхүйн хийгээд сургалт боловсролын шаардлага манай орны улс төрийн шинжлэх ухаан, тухайлбал улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаанд зохих ёсоор тавигдаж байна. Нэгдүгээрт, бид тоталитаризмын асуудлаар гарсан өрнөдийн томоохон эрдэмтэдийн зохиол бүтээл, тэр дотор Х.Арендтын зохиол, үзэл баримтлалтай бусдаас нэлээд хожимдон танилцаж одооноос л судлан

эхэлж байна. Эдүгээ эл хожимдолыг боломжийн хирээр нөхөж гүйцээх хэрэгтэй болж байгаа юм. Хоёрдугаарт, авч үзэн буй зохиолыг судлан шинжлэх явдал манай орны улс төрийн түүхийн тодорхой шатад тоталитар дэглэм үүсэн тогтож байсан асуудлыг судлан боловсруулахад зохих хэмжээний ач холбогдолтой байх болно. Гуравдугаарт, эл зохиолыг судлаж, түүний талаар ном товхимол, өгүүлэл, лекц, дипломын ажил бичиж нийтийн хүртээл болгох хэрэгтэй бөгөөд энэ нь тоталитаризмын талаархи бидний онолын ойлголт, мэдлэгийн сан хийгээд сургалт боловсролын гарын авлага, материалыг сэлбэн баяжуулах, гүнзгийрүүлэхэд ач тустай байх болно.

Бид эрдэмтэн багш нарынхаа дэмжлэг тусламжаар тоталитаризмын тухай Х.Арендтын үзэл баримтлалыг судлан эхлэж байгаа бөгөөд үүний өмнө нэгэн өгүүлэл нийтлүүлсний (5) үргэлжлэл болгож энэ удаа сэтгэгч зохиолдоо тоталитар хөдөлгөөнийг судлан шинжилсэн талаар товч авч үзэх зорилт тавив.

Тоталитаризмын тухай Х.Арендтын үзэл баримтлал ёсоор тоталитар дэглэм үүсэн бүрэлдэж, тогтон ноёрхоход нэгд, тоталитаризмын үзэл санаа, хоёрт, түүнд тулгуурласан зорилго, гуравт, тэдгээрийг сурталчлан дэлгэрүүлж олон түмэнд хүргэх, ухуулж үнэмшүүлэх, хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэгдсэн тоталитарист суртал нэвтрүүлэг, дөрөвт, тоталитар зохион байгуулалт, байгууллага зайлшгүй шаардлагатай болно. Эдгээрийн нийлбэр, нэгдлийг Х.Арендт тоталитар хөдөлгөөн (totalitarian movement - тоталитарное движение) гэж нэрлэжээ. Эл хөдөлгөөн хэрэг дээрээ тоталитаризмыг бэлтгэж үүсгэх анхны үе шат юм. Учир нь тоталитаризм өөрөө гэнт, эсвэл аяндаа үүсэн бий болохгүй, түүнийг нийгэм–улс төрийн тодорхой хүч, хөдөлгөөн зорилго чиглэлтэйгээр бэлтгэж үүсгэн тогтоодог нь түүхээс тодорхой болсон зүйл билээ.

Х.Арендтын зохиолын “Тоталитаризм” хэмээх гуравдугаар хэсэг (анги) бол тоталитаризм үүсэж бүрэлдэх, тогтож ноёрхох үйл явц, арга хэрэгсэл хийгээд эл дэглэмийн мөн чанар, бүрэлдэхүүний хэсэг, гол шинжүүдийн тухай асуудлыг шинжлэн авч үзсэн, тиймээс ч нэн сонирхолтой, гүнзгий утга санааг агуулсан гол хэсэг болно. Тэрбээр тоталитаризмыг сонгодог, хамгийн хатуу хахир хэлбэрээр тогтон ноёрхсон Герман, ЗХУ-ын жишээ туршлагын үндсэн дээр дэлгэрэнгүй авч үзсэн байна.

Тоталитаризм нийгмийн хэвийн нөхцөлд биш, харин нэг талаар түүний социал хүрээ, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдрал нь “бэртсэн”, хямралтай нөхцөлд, нөгөөтэйгүүр тийм нөхцөл байдлын төрүүлж бий болгосон “хүний материалаар” бий болж босдог, өөрөөр хэлбэл нь өөрт нь тохиромжтой нийгмийн бааз суурин дээр үндэслэж үүсдэг ажээ. Тэрхүү бааз суурь буюу “хүний материал” нь масс буюу олон түмэн юм. (Энд нэг зүйлийг дурдахад нийгмийн ухаан, тэр дотор социологид, тэгэхдээ өрнөдийн социологийн утга зохиолд голцуу сөрөг утга агуулгаар хэрэглэгддэг mass–масса гэдэг нэр томъёог монголоор шинжлэх ухааны оноосон утгаар орчуулан хэрэглэж хэвшээгүй, масс, өргөн олон, өргөн түмэн, олон нийт, олон түмэн гэсэн өдөр тутмын жирийн хэрэглээний утгаар янз бүрээр хөрвүүлэн хэрэглэж байгаа нь эрдэм шинжилгээний нэр томъёоны шаардлагыг тэр бүр хангахгүй байна. Тиймээс бид уг нэр томъёог “масс” гэсэн үгээр хэвээр нь хэрэглэв). Тиймээс Х.Арендт тоталитаризмд хийсэн шинжилгээгээ нэн түрүүнд түүний нийгмийн бааз суурь болох массын тухай асуудлыг нарийвчлан авч үзэхээс эхэлсэн байна.

Х.Арендтын судалгааны нэг чухал ололт, онцлог бол тэрбээр массын нийгэм, улс төрийн шинж чанар, байр суурь, ухамсар, сэтгэл зүйн дүр төрхийг нарийн шинжилж илэрхийлэн гаргасан явдал юм. Тиймээс ч масс, “массын нийгэм”- (mass society - массовое общество) ийн асуудлаархи үзэл баримтлалд түүний судалгаа багагүй нөлөөлжээ.

Х.Арендтын үзлээр массын нийгэм-улс төрийн гол шинж бол урьдын ажил мэргэжил, нийгэм, улс төрийн хэлхээ холбоо, ангийн харъяаллаасаа тасран салж хүнийссэн, ганцаарласан бодгалуудын механик нийлбэрээс бүрэлддэг явдал ажээ. “Массыг бүрдүүлэгч хүний гол шинж төрх бол харгис хэрцгий зан биш, хоцрогдол, бүдүүлэг зан ч биш, харин тэрээр тусгаарлагдсан, түүнд нийгмийн амьдралын хэвийн харилцаа дутсан явдал байдаг” (1,422). “Масс” гэсэн ойлголтыг нэг бол тоо хэмжээ, эсвэл идэвхгүй, хайхрамжгүй байдал, аль эсвэл энэ хоёр шинж нь хамссаны улмаас нийтлэг нэгэн эрх ашигт үндэслэсэн ямар нэг байгууллага, тухайлбал улс төрийн нам, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, үйлдвэрчний эвлэлд элсүүлэн оруулах аргагүй тийм хүмүүсийг илэрхийлэн тэмдэглэх зорилгоор хэрэглэнэ (1,414). Өөрөөр хэлбэл массад тодорхой нэг нийтлэг эрх ашиг байдаггүй, тиймээс улс төрийн хэвийн төлөөлөлгүй байдаг. Масс нь түүнчлэн нийгмийн ноёлогч ангийн аж амьдралын баримтлал, хэм хэмжээг өөртөө өвлөж эзэмшдэггүй, харин нийт ангийн баримтлал, хэм хэмжээг өөртөө тусгаж эвддэг байна. Массыг бүрдүүлдэг тусгаар, ганцаарласан бодгалуудын өөр нэг ноцтой шинж чанар бол тэд амин хувийн эрх ашиггүй болж хувирсан, өөрөөр хэлбэл өөрөө өөрөөсөө няцсан, өөртөө санаа зовох, айж түгшихгүй болсон явдал ажээ.

Гэхдээ масс ба түүнийг бүрдүүлдэг бодгалууд нийгэм, улс төрийн амьдрал, үйл явдалд огт хайхрамжгүй, дүлий дүмбэ байдаггүй ажээ. Харин ч өөрийгөө, хувийн амьдралаа гаргууд гаргаж мартсан хэрнээ улс төр, үзэл суртлын асуудал, арав, зуун жилээр хэмжигдэж хэрэгжих ерөнхий, хийсвэр, “агуу их” зорилт, асуудлыг сонирхон оролддог байна (1,420). Ийм сэтгэхүй, зан байдалтай үй олон бодгалуудаас бүрэлдсэн тоо хэмжээ, хүрээгээрээ асар их бөгөөд өргөн олон масс нь дэлхий дахин, тивийн хэмжээгээр бодож сэтгэдэг байна. Түүний эл шинж чанар бүхнийг хамарсан ноёрхол тогтоох зорилготой тоталитар дэглэмд, тухайлбал Германы фашист тоталитаризмын хувьд герман үндэстэн дэлхийг эзлэн ноёрхох, ЗХУ дахь коммунист тоталитаризм нь коммунизмыг дэлхий дахинд дэлгэрүүлж тогтоох агуу их зорилгод нь нэн нийцтэй, тохиромжтой байжээ (1,420 – 421).

Х.Арендт масс нь харц олоноос (crowd – толпа – хүн заарцаг) ялгаатай гэж үзээд харц олон бол ард түмний оронцог (1,166), нийгмийн бүх анги давхрааны хэлтэрхий, хугарсан хэсгээс бүрэлдсэн нийгмийн онцгой бүлэг (1,166), нийгэм-эдийн засгийн гарал үүслээрээ капиталист үйлдвэрлэл, тухайлбал түүний үе үе давтагддаг хямралын “хүн хаягдал”, “шаар” (1,219) гэжээ (1,166). Масс ХХ зууны эхээр бий болсон бол харц олон XIX зууны бүтээгдэхүүн байсан, түүхийн тавцангаас буусан ажээ. Харц олон нийгмээс хасагдаж гадна нь үлдсэн байдаг тул нийгмийг, улс төрийн хэвийн төлөөлөлгүй учираас парламентийг үзэн яддаг, хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, тэмцлийн үед өөрийн улс төрийн төлөөлөллийн төлөө биш, харин ямагт “хүчтэй бие хүн”, “агуу их жолоодогчийн төлөө” байдаг учираас улс төрийн хүчнүүд харц олныг хууль бус үйл ажиллагаа, гудамжны жагсаал цуглаан, тэмцэлд ашиглаж байсан түүх элбэг ажээ (1,166). “Масс ба харц олон хоёр хоёулаа нийгмийн байгууллагуудын гадна үлдсэн, улс төрийн хэвийн төлөөлөлгүй байдагаараа цорын ганц ижил, нийтлэг шинжтэй болно” (1,418).

Тоталитар дэглэмүүд засгийн эрхэнд байгаа цагт, тоталитаризмын удирдагчид амьд байгаа цагт эцэстээ хүртэл массын дэмжлэгийг ашигладаг, Гитлер, Сталин хоёрын аль нь ч массын итгэлийг олж дэмжлэгт нь тулгуурлахгүйгээр тоталитар төрийн засгийн эрхэнд байх боломжгүй байсан (1,408), аль нэг учир шалтгаанаар улс төрийн зохион байгуулалтад амтшсан масс байгаа бүх газарт тоталитар хөдөлгөөн үүсэн бий болох боломжтой (1,414), масс далд байдлаар улс орон бүрт байдаг бөгөөд тэдгээр орны төвийг сахисан, улс төрийн хувьд хайхрамжгүй, идэвхгүй, хэзээд ч, ямар ч намд нийлдэггүй үй олон хүмүүсийн ихэнх хэсэг нь байдаг (1,415), түүнчлэн

тоталитар хөдөлгөөн чухам массыг зорин чиглэж, зохион байгуулж түшиглэснээр амжилтад хүрч байсныг Х.Арендт дэлгэрэнгүй авч үзэж санаа бодлоо онцлон зааж тэмдэглэжээ (1,411).

Масс үүсэн бий болох урьдач нөхцөл, шалтгааныг Европт империализм, нэн ялангуяа дэлхийн нэгдүгээр дайн бий болгосныг Х.Арендт зохиолынхоо хоёрдугаар хэсэгт авч үзсэн байна. Тэрхүү нөхцөл, хөрс суурин дээр масс нийгмийн онцгой хэсэг болж XX зууны эхээр Европын олон оронд бий болжээ. Гэхдээ масс тэдгээр орнуудын дотроос чухам Герман, ЗХУ-д тоталитар дэглэм үүсэн тогтох нэн тохиромжтой бааз суурь болжээ. Масс нь Германд түүхэн тодорхой нөхцөл байдал, тэр дотор дэлхийн нэгдүгээр дайны учирлуулсан “нийгмийн бэртэл”, сүйрлийн уршигаар бий болсон бол ЗХУ-д түүнийг зөвлөлт засаг паспортын систем, хамтралжуулалт, хөдөлмөрийн биржийг хаах, хүмүүсийг бие биеэ хянах, матах, нөхөр эхнэр, эцэг эх, үр хүүхдийг хооронд нь улс төрөөр талцуулж гэр бүлийн ёс суртахууны үндэс, үнэт зүйлсийг нь алдагдуулах зэрэг арга хэрэгслээр зохиомолоор бий болгосон гэж Х. Арендт үзжээ.

Х.Арендт тийнхүү дээрхи байдлаар тоталитаризмд тохиромжтойгоор бүрэлдэн бий болсон нийгэм-эдийн засаг, улс төрийн урьдач нөхцөл хийгээд нийгмийн бааз суурь, “хүний материал” бүхий массыг шинжилсний дараа тэдгээрийг өөртөө шимтэй хөрс суурь болгон гарч ирсэн тоталитар хөдөлгөөний асуудлыг задлан авч үзсэн байна. Одоо тэр талаар өгүүлье.

Х.Арендт тоталитар хөдөлгөөн нь тоталитар засаглал буюу засгийн эрхийг бодитойгоор гартаа авсан тоталитар төрөөс ялгаатай, нэг ёсондоо тоталитаризмын бэлтгэл болохыг заажээ (1, 414). Тэрбээр үүнтэй холбогдуулж зарим оронд, тухайлбал ЗХУ-д тоталитар дэглэм тогтохоос өмнө тоталитар хөдөлгөөн байгаагүй, түүнийг уг дэглэм тогтсоны дараа үүсгэн өрнүүлсэн бөгөөд түүнд тохиромжтой нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөлийг зохиомолоор бий болгосон гэж бичжээ (1,430). Тоталитар хөдөлгөөн нь нийгмийн төлөвшин тогтсон анги, нийгэм, улс төрийн тухай өөрийн гэсэн үзэл бодол, чиг баримжаа, ухамсартай иргэдэд биш, чухам массад хандаж түшиглэн гарч ирдэг, түүнийг зохион байгуулалтад оруулж чадснаар л амжилтад хүрдэг ажээ (1, 411).

Масс байгаа улс орнуудад тоталитар дэглэм үүсэн гарч ирэх боломжтой болохыг дэлхийн нэгдүгээр дайны дараах Европын орнуудын туршлага нотлон харуулсан байна. Гэхдээ тэдгээр оронд үүсэн дэлгэрсэн хөдөлгөөнүүд бүгдээрээ тоталитар шинжтэй байгаагүй ажээ. Х.Арендт үүнтэй холбогдуулж фашист ба тоталитар хөдөлгөөн, ер нь фашизм ба тоталитаризм хоорондоо ялгаатай гэж заажээ. Тухайлбал “тоталитар төр” гэсэн нэр томъёо, ойлголтод тун дуртай байсан Муссолини хэрэг дээрээ жинхэнэ тоталитар дэглэм тогтоохыг оролдоогүй, зөвхөн нэг намын засаглалтай диктатур л тогтоосон (1,411), түүнчлэн фашист ба тоталитар хөдөлгөөн үндэсний армид хандах хандлагаараа ялгаатай, нацист ба большевикуудын тоталитар дэглэм армийн дайчин урам зориг, үндэсний үзэл санааг алдагдуулж улс төрийн комиссаруудад захируулсан байхад фашистууд армийг сэтгэл санаагаар дэмжиж өөрийн зорилгодоо сайтар ашиглажээ (1,352). Испанид тогтож байсан фашист дэглэм тоталитаризмаас ялгаатай диктатур байсан, тиймээс ч Франко өөрийн улсын еврейчүүдийг алж хядаагүй ажээ.

Улс төрийн аль ч байгууллага, хөдөлгөөний хүч чадал, нөлөө нь тэдгээрийн гишүүд, дэмжигчдийн тоо хэмжээнээс шалтгаалдаг. Гэтэл тоталитар хөдөлгөөнд дэмжигчдийн чанарлаг тоо биш харин их хэмжээний дан тоо шаардлагатай байдаг, үүний улмаас хүн ам цөөн, жижиг улс оронд тоталитар дэглэм тогтох боломжгүй ажээ (1,411). Европын жижиг орнуудад ч дэлхийн нэгдүгээр дайны дараа тоталитар хөдөлгөөн өрнөж байсан боловч эцэстээ тоталитар дэглэм тогтоогүйн шалтгаан бол

тэдгээр орны хэмжээ, хүн амын тоо толгой нь тоталитаризмын дэндүү том зорилго, шаардлагыг нь даахааргүй байсанд оршино (1,413). Ер нь хүн ам ихтэй, тэр дотор масс илүүдэлтэй, тэдгээрийн мэдэгдэхүйц хэсгийг бөөнөөр хорих лагерьт үй олноор нь алж хядлаа гэхэд тэр нь хүн амын популяци, нөхөн үржихүйд нь аюул сүйтгэл учируулахааргүй том улс оронд тоталитар дэглэм тогтож ноёрхох боломж өндөр байдаг ажээ (1,414).

1930 оноос хойш Германд нацист тоталитар хөдөлгөөн, Европын бусад оронд коммунист маягийн тоталитар хөдөлгөөн хүчээ авч өрнөсний нэг ноцтой шалтгаан бол эдгээр хөдөлгөөнүүд тухайн орнуудын улс төрийн намуудад гологдож илүүдэл болж хаягдсан массаас өөрийн гишүүд дэмжигсэдийг хялбархан олж олноор элсүүлсэнд байжээ (1,415). Тэдгээр нь урьд өмнө улс төрийн тавцанд огт гарч байгаагүй хүмүүс байв. Энэ нь тоталитар хөдөлгөөнд олон талаараа ач тустай болж соёлт европынхны санаанд оромгүй ололт амжилтад хүрэх, тухайлбал Гитлер засгийн эрхэнд гарч ирж дэглэмээ тогтооход ихээхэн нөлөөлжээ.

Масс ба тоталитар хөдөлгөөн хоорондоо уялдаж холбогдсны үр дүн юу байсныг Х.Арендт анхааралтай судлан шинжилсэн байна. Тэдгээр нь, нэгдүгээрт, тоталитар хөдөлгөөн массыг талдаа татан, зохион байгуулж өөрийгөө дэмжүүлж чадснаар улс төрийн намуудын гадна, тэдгээрийн эсрэг үйл ажиллагаа өрнүүлэх боломжтой болсон, хоёрдугаарт, өөрийн зорилго, бодлогыг сурталчилах, эсрэг талын хүч, улс төрийн намуудын бодлого, зорилго, программын үзэл санааг хялбархан няцаах, үл тоох цоо шинэ арга хэрэгсэл бүхий боломжтой болсон, тухайлбал өрсөлдөн сөргөлдөгч намуудын алинтай нь ч шударгаар өрсөлдөх шаардлагагүй болсны хамт нөгөөтэйгүүр тэдгээрийн алиныг ч үзэн ядаж дайсагнасан улс төрийн туршлага, ухамсар, соёлгүй өөрийн гишүүд дэмжигч масстай санаснаараа харьцан ажиллах, тэднийг өөрийн үзэл суртлаар боловсруулж бэлтгэх бололцоотой болсон явдал байжээ. Гуравдугаарт, тоталитар хөдөлгөөнүүд массыг зохион байгуулж амжилтад хүрсэн явдал нь ардчилсан засаглалтай орнууд болон тэдгээрийн намын системийн хоёр янзын хуурмаг явдал, төөрөгдөлийг илчилж замхруулсан байна. Тэдгээрийн нэг нь ардчилсан оронд ард түмний ихэнх хэсэг нь улс орныг удирдах үйл хэрэгт идэвхтэй оролцдог, хувь хүн бүр өөрийн, эсвэл ямар нэг намыг талархан дэмждэг гэсэн үзэл байв. Гэтэл энэ нь хэрэг дээрээ тийм биш, харин ардчилал нь идэвхтэй цөөнхийн хүлээн зөвшөөрсөнөөр, дэмжлэгээр л оршин байдагийг, ардчилсан удирдлагатай оронд улс төрийн байр сууриараа төвийг сахисан, эсвэл улс төрд хайнга, идэвхгүй ханддаг өргөн олон түмнийг учирыг нь олж зохион байгуулж чадвал тэд төвөггүйгээр жинхэнэ олонхи болж чаддагийг тоталитар хөдөлгөөнүүдийн туршлага тод харуулжээ (1,415). Хоёр дахь төөрөгдөл, хуурамч зүйл нь улс төрийн хувьд хайнга, идэвхгүй масс нь тухайн үндэстэн, ард түмний улс төрийн амьдралын гадна талын, зохион байгуулалтгүй, хоцрогдсон, өнгө будаг төдий орчин нь байдаг гэсэн ойлголт байв. Гэтэл тийм биш, ардчилсан засаглал нь ард түмний тэрхүү зохион байгуулалтгүй, идэвхгүй, хайнга хэсгийн дуугүй, далд сайшаал талархал ба хүлцэл тэсвэрт ч тодорхой хэмжээгээр тулгуурлан тогтож байсныг тоталитар хөдөлгөөнүүд ил болгон харуулжээ. Чухам ийм байсныг мэдэрсэн тоталитар хөдөлгөөн массыг талдаа татаж үзэн ядагдсан парламентыг дайран довтолж, парламент нь ард түмний олонхийн хууль ёсны төлөөлөл гэдэг нь хуурмаг юм, парламент нь улс орны бодит байдалд тохирохгүй байна гэж ард түмний олонхийг итгүүлж чаджээ. Энэ нь бас олонхийн засаглалд итгэн хүндэтгэж байсан засгийн газрыг ч эргэлзээнд оруулж өөрийгөө хүндэтгэх итгэл хүндэтгэлийг нь гутаажээ (1,416).

Х.Арендт шинжилгээгээ цааш гүнзгийрүүлж, масс нь нийгмийн үйл хэрэгт хайнга ханддаг, улс төрд оролцдоггүй нь өөрөө дангаараа тоталитар хөдөлгөөн аяндаа гарч

ирж өсөн өндийх хүрэлцээтэй үндэс шалтгаан болохгүй, үүнд өөр нарийн учир шалтгаан байгааг гаргаж тавьсан байна. Тэр нь юу байна вэ гэвэл нэгдүгээрт, хатуу өрсөлдөөнд тулгуурласан, шунахайран завшигч хөрөнгөтний нийгэм нь нийгмийн амьдралд дайсагнан хандах хорсол, үзэн ядалтыг капиталд мөлжигдсэн, улс орныг удирдах идэвхтэй оролцооноос зайлуулагдаж дарлагдсан доод анги давхраанд төдийгүй мөн өөрийн хөрөнгөтөн ангийнханд ч төрүүлэн бий болгожээ. Үндэсний хөрөнгөтөн нь нийгэмд ноёлогч анги байсан хирнээ улс төрийн удирдлагад үл оролцож бизнесийн хүрээнд л эргэлдэж байсан нь хуурамч даруу зан болох нь империализмын үе эхлэж хөрөнгөтнүүдийн “од гийх” үед тодорхой болсон байна. Эл үед хөрөнгөтөн анги үндэсний төр улсын нийгмийн болон улс төрийн байгууллагуудад хорсолтой, дайсагнаж хандах нь хүчтэй болж, засгийн эрхэнд гарах бэлтгэлээ хийж зохион байгуулагдах болжээ. Хөрөнгөтөн анги өмнө нь улс төрөөс хөндий, дараа нь түүнд шургуу тэмүүлэн оролцох болсон нь түүний амьдралын философи хийгээд аж төрөх ёстой нягт холбоотой байв. Хөрөнгөтний нийгэм дэх хувь хүний амьдрал, тэр дотор хөрөнгөтний өөрийнх нь хувь заяа ч гэсэн хайр найргүй хатуу өрсөлдөөнөөр тодорхойлогдож, нэг бол ололт, ашиг орлого, эсвэл дампуурал, сүйрэл гэсэн хоёр туйлын нэг нь хүлээдэг байв. Ийм нөхцөлд иргэд, хүн ард улс орон, нийгмийнхээ төлөө санаа зовж иргэний үүрэг, хариуцлагатай байх гэж чармайх нь аж амьдралдаа зориулах алтнаас үнэтэй цаг зав, хүч энергиэ хий дэмий үрэхэд хүргэдэг байлаа. Энэ байдал хөрөнгөтний нийгмийн гишүүд, хүн ардын нийгэм-улс төрийн оролцоо, идэвхийг сулруулж хайнга болгожээ (1,417).

Хоёрдугаарт, Европын үндэсний төр улсуудын хүн ардын нийгэм, улс төрийн давхраажилтын цорын ганц тогтолцоо, суваг нь ангийн тогтолцоо, хүмүүс нийгмийн анги давхраанд хуваагдаж, түүгээр дамжин нийгэмд байр суурь эзэлж, үүрэг гүйцэтгэдэг тогтолцоо байв. Ийм тогтолцооны нөхцөлд тодорхой ангид харъяалагдсан хувь хүн нийгэм, улс төрийн амьдралд өөрөө бие дааж, ганцаарчилан оролцдоггүй, мөн нийгэм-улс төрийн ажил үүрэг, асуудал, зорилттой ч дангаараа, хувиараа тулгардаггүй, тиймээс тэдгээрийн төлөө санаа зовох, хариуцлага хүлээх хэрэгцээ гардаггүй байжээ. Нийгэмд анги, ангийн системийн үүрэг, ач холбогдол өсөхийн хирээр түүний гишүүдээс тодорхой тооны идэвхтэнүүдийг сонгон авч ирээдүйн мэргэжлийн улс төрч, төр засгийн ажилтан, парламентын гишүүнд бэлтгэдэг байв. Ийм нөхцөлд ард түмний олонхи нь намын болон улс төрийн бусад байгууллага, тогтолцооны гадна үлдэж тэднийг хэн ч ойшоон анхаарахгүй болжээ. Энэ байдал нийгэм-улс төрийн амьдралд хайхрамжгүй, хувийн хариуцлага, бие даасан, ухамсарт чанар дорой иргэдийн тоо өсөхөд хүргэсэн байна. Өөрөөр хэлбэл европын нийгмийн ангийн бүтэц нь өөрөө хүн амын дунд улс төрөөс хөндий, идэвхгүй, үүрэг хариуцлагагүй байдал бий болоход нөлөөлжээ (1, 418 – 419).

Гуравдугаарт, Европын орнуудад ХХ зууны эхний хэдэн арван жилд нийгмийн ангийн систем (ангийн бүтэц) эвдэрч задарснаар ангиудын эрх ашгийг илэрхийлэхийн тулд байгуулагдан үйлчилж ирсэн улс төрийн нам, намуудын систем давхар задран нурсан байна. Намууд ийм шинэ, ээдрээтэй нөхцөлд нийгмийн залуу үеийнхний дотроос гишүүд элсүүлж хүч сэлбэх, дэмжигчидээ нэмэгдүүлэх ажил хэрэгч алхам хийж чадаагүй, бүхэлдээ идэвхгүй, өнгөрснөө санагалзах, хориглож хамгаалах байдалтай болсон байна. Үүний дээр намууд улс төрийн хувьд хайнга, нийгмийн идэвхгүй, зохион байгуулалтгүй ч гэсэн намуудыг хөндлөнгөөс далдуур, дуугүй дэмждэг массыг алдсан байлаа. Тиймээс Европын эх газрын намын системийн сүйрлийн эхний чухал шинж тэмдэг нь ахмад хуучин гишүүд нь намаасаа гарч нуугдах болсон явдал биш, харин шинэ гишүүд элсүүлж чадахгүй болсны дээр массын далд, идэвхгүй дэмжлэгийг алдсан явдал байв.

Тийнхүү Европын орнуудын нийгмийн уламжлалт бүтэц, ангийн болон намын систем задарч нурснаар урьд нь тэдгээрийн хамгаалалтын хананы гадна хүлцэнгүй ноомой, нойрмог байсан олонхи тэр байдлаа сэгсэрч хаяаад хорсож хилэгнэсэн масс болж хувиран, шинээр үүсэн гарсан нийгэм-улс төрийн хөдөлгөөнүүд, тэр дотор нэн түрүүнд тоталитар хөдөлгөөнд үтэр түргэн хандаж шударга бус нийгэмд дайсагнасан хорсол хилэгнэлээ чанга дуугаар гарган илэрхийлэхээр идэвхтэй оролцох болсон байна (1,419).

Х.Арендт тоталитар хөдөлгөөний бусад хөдөлгөөнүүдээс ялгаатай гоц, чухал шинж чанаруудыг авч үзжээ. Тэдгээрийн эхнийх нь тоталитар хөдөлгөөн өөрийн гишүүдээс хөдөлгөөндөө бүх талаараа (тотал), хэмжээгүй, ямар ч болзолгүй, хувирашгүй, чин үнэнч байхыг шаарддаг явдал юм. Тоталитар хөдөлгөөний удирдагчид үүнийг гишүүдээсээ засгийн эрхэнд гарахаас өмнө ч шаарддаг ажээ. Хүн, бодгалын хувьд нийгмийн аливаа хэлхээ холбоо, тухайлбал гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагсад, түүгээр ч үл барам жирийн танилуудаасаа ч гэсэн хөндийрэн тасарсан нөхцөлд л тийнхүү тоталитар хөдөлгөөнд үнэнч байх боломжтой юм. Учир нь хүн зөвхөн ийм тохиолдолд л тоталитар хөдөлгөөн бол түүний энэ насны, энэ ертөнц дэх цорын ганц бат бэх орон зай хэмээн итгэн үнэмших ажээ (1,430). Энэ нь түүний гишүүд хэт шүтлэгтэн, бишрэн зүтгэгч болгоход хүргэнэ. Үүний цаад үндэс шалтгаан бол тоталитар хөдөлгөөний гишүүд бүхий массаас гаралтай хүмүүс нь хувийн амьдралаа гээсэн, амин хувийн эрх ашиггүй, тиймээс ч өөрийгөө уг хөдөлгөөний үйл хэрэгт бүрэн зориулах боломжтой байдаг явдал ажээ (1, 459).

Гишүүн нь тоталитар хөдөлгөөнд чин үнэнч байхын тулд түүний үзэл санааны итгэл үнэмшил нь бодит биш, тодорхой агуулгагүй, харин хийсвэр байх ёстой. Тоталитар хөдөлгөөний удирдагчид үүнийг хангаж хэрэгжүүлэхийн тулд нэн түрүүнд намын мөрийн хөтөлбөрөөс татгалзах, ямар нэг хөтөлбөргүй байхыг хичээдэг байна. Учир нь аль ч намын мөрийн хөтөлбөр тодорхой зорилго, зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги, тактикийн алхамуудыг чухалчлан заадаг уламжлалтай юм. Гитлер өөрийн үүсгэсэн тоталитар хөдөлгөөнөө тийм мөрийн хөтөлбөрөөс ангижруулж чадсан нь түүний амжилтын нэг чухал алхам байжээ (1,430). Гэхдээ намын мөрийн хөтөлбөргүй байх, эсвэл түүнийг үл хайхрах нь тоталитаризмын зайлшгүй чухал шинж биш ажээ. Намын болон сонгуулийн мөрийн хөтөлбөр, бусад баримт бичиг бол хэнд ч хэрэггүй уранхай тасархай цаас гэж анх үзсэн удирдагч бол Муссолини байв. Гэвч түүний толгойлсон хөдөлгөөн тоталитар биш, фашист хөдөлгөөн байсан бөгөөд тэрбээр юуг зорьж хэрэгжүүлэхээ товч тодорхой, ажил хэрэгч илэрхийлж байсан онцлогтой ажээ (1,432).

Тоталитар хөдөлгөөн, дэглэмийн аль алины чухал шинж, элемент бол цорын ганц удирдагч, жолоодогчтой байх явдал юм. Тэрбээр хөдөлгөөний мотор болж гол төвд нь байна (1,490). Жолоодогч байхын тулд зөвхөн хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх явдал хүрэлцээтэй биш. Үүнд тэрбээр тойрон хүрээлэгчдийгээ нууц явуулгаар байнга өөрчилж сэлгэх, далдуур хөнөөх, хууран мэхлэх, түүнчлэн зохион байгуулах, удирдах авъяас чадвартай, ажил хэрэг, үйл явдлыг нарийн гярхай ажиглаж мэдэрдэг зэрэг шинж чанар шаардлагатай болно (1,491). Ийм шинж чанар жолоодогчод ялангуяа тоталитар хөдөлгөөний үед нэн шаардлагатай байх ба харин засгийн эрхэнд гарч бат бэх болсны дараа шийдвэрлэгч үүрэгтэй биш болдог байна.

Жолоодогчийн гол шинж бол тэрбээр алдаа эндээгүй байдаг явдал болж тоталитар хөдөлгөөн, дэглэмийн практикт хэвшжээ. Энэ шинж чанар түүний ер бусын оюун ухаанаар биш, харин зохиомолоор, зорилго чиглэлтэйгээр бий болно.

Жолоодогчийн эрхэм дээд зорилт нь тоталитар хөдөлгөөн, дэглэмийг нэг талаар гадаад ертөнцөөс хамгаалдаг ид шидтэй хамгаалагч, нөгөөтэйгүүр хөдөлгөөнийг гадаад ертөнцтэй холбогч гүүрийн үүрэг гүйцэтгэх явдал болно.

Жолоодогч хөдөлгөөний ололт амжилт, алдаа дутагдал, ер бүх үйлдэл, үйл хэргийнх нь төлөө хувийн хариуцлага хүлээхийг ажилтнуудаасаа хатуу шаардахын хамт ажилтнуудыг нь шүүмжлэн зэмлэхийг бас хориглоно (1,492).

Тоталитар хөдөлгөөн суртал нэвтрүүлгийг чадамгай ашиглан, бас өөртөө оновчтой нийцэж тохирсон зохион байгуулалтын хэлбэрийг олж, салбар сүлжээ бүхий байгууллагуудыг үүсгэн бэхжүүлж, тэдгээрийг олон эд ангиас бүтсэн машины хөдөлгүүр мэт жигд ажиллуулж чадснаар засгийн эрхэнд гарч тоталитар төр бий болжээ. Үүгээр урьдын тоталитар хөдөлгөөн, байгууллагууд төрийн жинхэнэ тоталитар машин болон хувирч “хүн хэмээх материалаар” юу хийж чаддагаа харуулсан гэж Х.Арендт бичжээ.

Ашигласан ном зохиол

1. Арентт Х. Истоки тоталитаризма. Перевод с английского. М., 1996. - 670с.
2. Бутенко А.П. От коммунистического тоталитаризма к формированию открытого общества в России (политические и правовые проблемы). М., 1997. – 48 с.
3. Всемирная история. Учебник для вузов / Под ред. Г.Б. Поляка, А.Н. Марковой. М., 2000. – 742 с.
4. Тоталитаризм. Из истории идеологий, движений, режимов и их преодоления / Руководитель авторского коллектива Я.С. Драбкин, Н.П. Комолова. М., 1996.– 540 с.
5. Жаргал Ж. Тоталитаризмын үүслийн талаархи Ханна Арентдын үзэл баримтлалын тухайд. – Философи, эрх зүйн судлал. XXII боть. УБ., 2007, 246 – 252 дахь талд.